



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.4.2 Авлага	11
3.4.3 Бараа материал	12
3.4.4 Үндсэн хөрөнгө	12
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт тэсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6.1 Завсрын аудитын талаар	19
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № СА-2025/005/НА-СТН-773
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1, Төрийн албаны тухай хуулийн 50.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал” 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2, Тэгш ундрэм ХХК-тай байгуулсан СЭАЗБСЗДТГ/202309027 тоот гэрээний 1.3 дахь заалтуудыг зөрчсөн

• 4325023923

бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Бэлчир 2 дугаар багийн хорооллын гудмуудад хайрган хучилттай 3 дугаар зэргийн замын далан тавих” ажлын санхүүжилтээс уг төсөл арга хэмжээг гүйцэтгэх ажлын гэрээнд тусгагдаагүй **3,000.0** мянган төгрөгийг “Мөнх эрдэм оюу ХХК”-д шилжүүлж, байгууллагаас авах авлага үүсгэсэн,
- Үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн С.Бат-Эрдэнийн ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг ЗДТГ-ын төсвөөс барагдуулсан боловч гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэлгүйгээр **12,182.4** мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **2,868.9** мянган төгрөгийн зөрчил илэрсэн,
- Тайлант онд ЗДНХ-өөс жил бүр давтагддаг урьдчилан төлөвлөх боломжтой тохижилт, үйлчилгээний буюу нохой устгалд **2,000.0** мянган төгрөгийг зарцуулсан,
- Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Сумын ИТХ-ын “Зүүнбүрэн сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 29 дүгээр тогтоолоор тайлант онд 993,020.4 мянган төгрөгийн татварын орлого, 12,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **1,005,020.4** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **957,716.0** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.7 дахин тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс малын хөлийн татварын 120,000.0 мянган төгрөгийг сумын суурь орлогод нэмж баталснаас шалтгаалан санхүүгийн дэмжлэг уг дүнгээр бага батлагдсан тул зардлаа нөхөхийн тулд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс төлөвлөгөө 47,304.4 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар тасарч, өр төлбөр үүсэх эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Зүүнбүрэн сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **89.8** хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	460,011.5	580,106.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	293,779.0	487,835.9
33	АВЛАГА	119,350.4	32,088.4
35	БАРАА МАТЕРИАЛ	46,882.0	60,182.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,994,520.1	2,584,804.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,994,520.1	2,584,804.0
39200	Биет хөрөнгө	1,978,802.3	2,428,375.8
39300	Биет бус хөрөнгө	15,717.8	156,428.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,454,531.6	3,164,910.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
41300	Өглөг	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,454,531.6	3,164,910.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,454,531.6	3,164,910.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	297,811.3	297,811.3
51200	Хуримтлагдсан үр дүн	1,690,495.3	2,400,874.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,225.1	466,225.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,454,531.6	3,164,910.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,693,445.6	2,859,577.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	656,701.0	944,523.7
110	Орлогын албан татвар	331,429.7	543,603.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	346,478.8	558,469.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,049.0	-14,866.0
113	Хөрөнгийн албан татвар	84,925.8	169,260.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	240,345.5	231,659.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,108.7	685,994.5
120	Нийтлэг татварын бус орлого	242,108.7	685,994.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	794,635.9	1,229,059.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,308,641.2	1,735,782.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,308,641.2	1,735,782.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,306,141.2	1,676,583.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,869.1	809,069.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,060.8	99,310.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,673.4	386,195.7
2104	Хангамж, бараа материалын зардал	51,206.8	40,949.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,863.1	25,501.2
2107	Томилолт, зочны зардал	8,715.9	5,896.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,881.4	12,011.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	283,870.7	297,649.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500.0	59,199.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	384,804.4	1,123,794.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	349,388.8	413,415.7

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	35,415.6	710,379.1
----	---	----------	-----------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,416,817.9	2,416,817.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,298.1	2,298.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,419,116.1	2,419,116.1
9	Тайлант үеийн үр дүн	35,415.6	35,415.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,454,531.6	2,454,531.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,454,531.6	2,454,531.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,454,531.6	2,454,531.6
19	Тайлант үеийн үр дүн	710,379.1	710,379.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,164,910.8	3,164,910.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,529,640.5	2,287,807.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	656,701.0	944,523.7
110	Орлогын албан татвар	331,429.7	543,603.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	346,478.8	558,469.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,049.0	-14,866.0
113	Хөрөнгийн албан татвар	84,925.8	169,260.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	240,345.5	231,659.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	215,621.1	113,875.2
1181	Газрын төлбөр	22,529.9	115,644.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,194.5	2,140.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,303.6	114,223.9
120	Нийтлэг татварын бус орлого	78,303.6	114,223.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	794,635.9	1,229,059.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,145,373.8	1,657,130.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,145,373.8	1,657,130.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,142,250.9	1,597,931.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,844.1	813,894.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,080.6	99,118.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,673.4	386,394.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,289.8	37,987.7
2105	Нормативт зардал	1,118.7	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,769.0	27,161.6
2107	Томилолт, зочны зардал	8,715.9	5,896.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	336,038.4	19,648.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,721.0	206,829.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,122.9	59,199.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	384,266.6	630,676.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	419,528.1	436,619.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	419,528.1	436,619.8
2200	Дотоод эх үүсвэрээр	419,528.1	436,619.8

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-419,528.1	-436,619.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-27,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	27,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-62,261.5	194,056.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	356,040.5	293,779.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	293,779.0	487,835.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,572,696.4	2,092,478.7	-480,217.7	81.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,812,419.6	1,680,875.0	-131,544.7	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,751,986.8	1,621,675.5	-130,311.3	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	864,908.6	813,894.9	-51,013.7	94.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,363.2	99,118.4	-18,244.8	84.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	407,046.9	386,394.0	-20,652.9	94.9
2104	Хангамж, бараа материалын зардал	47,702.4	37,269.1	-10,433.3	78.1
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,456.5	51,161.7	-4,294.9	92.3
2107	Томилолт, зочны зардал	7,482.2	5,896.2	-1,586.0	78.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,943.2	20,111.9	-11,831.3	63.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	219,083.8	206,829.3	-12,254.5	94.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,432.8	59,199.4	-1,233.4	98.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,432.8	59,199.4	-1,233.4	98.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	626,263.6	411,603.8	-214,659.8	65.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	134,013.2	0.0	-134,013.2	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,572,696.4	2,562,520.1	-10,176.3	99.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,287,679.5	2,004,041.2	-283,638.4	87.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	285,016.9	101,031.6	-183,985.3	35.4
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	222,426.7	222,426.7	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	235,020.7	235,020.7	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60	60	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,629.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,629.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271.48
2104	Хангамж, бараа материалын зардал	718.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	552.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,358.27
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,358.27
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,629.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,629.75

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэн ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- *Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах,*
- *Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах,*
- *Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох,*
- *Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,*
- *Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,*
- *Тухайн шатны ИТХ-ын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх,*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн байна. Мөн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зүүнбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 710,379.2 мянган төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	293,779.00	487,835.90	194,056.90
Авлага	119,350.40	32,088.40	-87,262.00
Бараа материал	46,882.00	60,182.50	13,300.50
Үндсэн хөрөнгө	1,994,520.10	2,584,804.00	590,283.90
Нийт хөрөнгө	2,454,531.50	3,164,910.80	710,379.30
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,454,531.60	3,164,910.80	710,379.20
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,454,531.60	3,164,910.80	710,379.20

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 487,835.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 194,056.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	293,779.00	487,835.90	194,056.90
Төгрөг	293,779.00	487,835.90	194,056.90
Төрийн сангийн харилцах	293,779.00	487,835.90	194,056.90
Дүн	293,779.00	487,835.90	194,056.90

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 252,815.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 62,659.3 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 172,361.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 32,088.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,262.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	2,308.10	2,076.80	-231.30
Байгууллагаас авах авлага	7,385.80	3,000.00	-4,385.80
Хувь хүмүүсээс авах авлага	0.00	12,182.40	12,182.40

Хувь хүмүүст олгосон зээл	56,283.90	14,827.60	-41,456.30
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	53,372.60	1.60	-53,371.00
Дүн	119,350.40	32,088.40	-87,262.00

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 52.6 хувь буюу 16,906.0 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 10,327.2 мянган төгрөг буюу 61.1 хувь нь 2011-2013 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 60,182.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,300.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.00	0.00	0.00
Тусгай зориулалттай материал	0.00	0.00	0.00
Эм боох материал	0.00	0.00	0.00
Хангамжийн материал	46,882.00	60,182.50	13,300.50
Бичиг хэргийн материал	4,149.70	4,627.80	478.10
Аж ахуйн материал	11,365.20	11,645.20	280.00
Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00	0.00
Түлш, шатах тослох материал	960.00	280.00	-680.00
Хүнсний материал	0.00	0.00	0.00
Бусад хангамжийн материал	30,407.10	43,629.50	13,222.40
Мал амьтад	0.00	0.00	0.00
Дүн	46,882.00	60,182.50	13,300.50

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 13,300.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 81,934.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 68,634.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 411,603.8 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад хангамжийн материалын дансаар дамжуулан хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,584,804.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 590,283.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,978,802.30	2,428,375.80	449,573.50
Барилга, байгууламж, орон сууц	955,550.10	972,001.10	16,451.00
Авто-тээврийн хэрэгсэл	190,064.80	394,630.50	204,565.70
Машин тоног төхөөрөмж(компьютер)	40,853.60	47,568.50	6,714.90

Тавилга, аж ахуйн эд хогшил	21,997.90	84,812.20	62,814.30
Дуусаагүй барилга байгууламж	253,899.80	356,280.80	102,381.00
Номын фонд	0.00	0.00	0.00
Бусад үндсэн хөрөнгө	516,436.10	573,082.70	56,646.60
Биет бус хөрөнгө	15,717.80	156,428.20	140,710.40
Программ хангамж	15,717.80	156,428.20	140,710.40
Бусад биет бус хөрөнгө	0.00	0.00	0.00
Дүн	1,994,520.10	2,584,804.00	590,283.90

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 590,283.9 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Аймгийн Замын сангийн хөрөнгө болон сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 117.9 мянган төгрөгийн хайрган хучилттай зам шилжүүлэн авсан,
- Онцгой байдлын Ерөнхий газрын дэргэдэх 185-р ангиас 149.2 сая төгрөгийн Ланд-78 автомашин, Сэлэнгэ аймгийн байгаль орчны газраас 5.1 сая төгрөгийн Мотоцикл шилжүүлэн авсан.
- Тамгын газарт бүртгэлтэй 17 нэр төрлийн 140.7 сая төгрөгийн газрыг хөрөнгөд бүртгэж авсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.4.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,164,910.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 710,379.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	297,811.30	297,811.30	0.00
Хуримтлагдсан үр дүн	1,690,495.20	2,400,874.40	710,379.20
Өмнөх үеийн үр дүн	1,655,079.60	1,690,495.30	35,415.70
Тайлант үеийн үр дүн	35,415.60	710,379.10	674,963.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,225.10	466,225.10	0.00
Дүн	2,454,531.60	3,164,910.80	710,379.20

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 710,379.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 29 дүгээр тогтоолоор 993,020.4 мянган төгрөгийн

татварын орлого, 12,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого нийт **1,005,020.4** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **957,716.1** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг **4.7** хувиар тасалсан байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	993,020.40	944,523.80	-48,496.60	95.1
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	340,000.00	383,689.30	43,689.30	112.8
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	105,652.00	149,537.70	43,885.70	141.5
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,000.00	4,590.40	590.40	114.8
Хөрөнгийн орлого	17,000.00	20,762.80	3,762.80	122.1
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	4,399.80	4,479.80	80.00	101.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,866.00	-14,866.00	0.00	100.0
Бууны албан татвар	960.00	2,070.00	1,110.00	215.6
Малд ногдуулах албан татвар	139,999.40	162,600.10	22,600.70	116.1
Улсын тэмдэгтийн хураамж	1,733.00	2,137.20	404.20	123.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	288,544.80	108,350.00	-180,194.80	37.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,364.00	3,388.00	24.00	100.7
Газрын төлбөр	43,331.90	50,149.50	6,817.60	115.7
Газрын дуудлага худалдаа	56,768.50	65,494.80	8,726.30	115.4
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	10.00	10.00	0.00	100.0
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	210.00	210.00	0.00	100.0
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1,913.00	1,920.20	7.20	100.4
Татварын бус орлого	12,000.00	13,192.30	1,192.30	109.9
Хүү, торгуулийн орлого	12,000.00	13,192.30	1,192.30	109.9
Нийт дүн	1,005,020.40	957,716.10	-47,304.30	95.3

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 43,689.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар 43,885.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь 12 дугаар сард олгогдсон хувьцааны ногдол ашгаас татвар суутгаснаас шалтгаалсан,
- Малд ногдуулах албан татварын орлого 22,600.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны татварын өрийг барагдуулснаас шалтгаалсан,

Тасарсан орлогууд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 180,194.8 мянган төгрөгөөр тасарсан нь уг орлогыг үндэслэлгүй өндрөөр төлөвлөсөн болон карьер гэрээгээр ашиглуулах төлөвлөгөөтэй байсан аж ахуйн нэгж байгууллагууд болон иргэд хайрга дайрга ашиглаагүй зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,163,353.3 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 444,880.1 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **1,608,233.4** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 44 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 936,228.4 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 883,191.5 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 3,648.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 328,714.2 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 450,821.7 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 64,418.6 мянган төгрөг зэрэг нийт **2,667,022.4** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 29 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг **94,236.0** мянган төгрөгөөр бууруулж, **2,572,696.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 40,000.0 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын орлогыг 53,365.5 мянган төгрөгөөр,
- Хөрөнгө борлуулсны албан татварыг 3,167.6 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын буцаалтыг 140.0 мянган төгрөгөөр,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 73,603.6 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөрийг 331.9 мянган төгрөгөөр,
- Малын тоо толгойн албан татварыг 9,620.4 мянган төгрөгөөр,
- Аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 7,352.5 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 14,172.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 8,000.0 мянган төгрөгөөр,
- Галт зэвсгийн албан татварыг 140.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамжийг 567.0 мянган төгрөгөөр,
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 9,990.0 мянган төгрөгөөр,
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 972.0 мянган төгрөгөөр,
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийг 8,087.0 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 4,636.0 мянган төгрөгөөр,
- Газрын дуудлага худалдааны орлогыг 26,231.5 мянган төгрөгөөр,

- Хөрөнгийн орлогыг 27,357.8 мянган төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлогыг 18,000.0 мянган төгрөгөөр,
- Хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлогыг 10,449.7 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 185,021.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ОНХС-г 6,343.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 86,669.3 мянган төгрөгөөр,
- Цэцэрлэгийн тогтмол зардлыг 14,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 890,544.0 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 342,886.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 265,800.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 64,418.6 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 1,005,020.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 4,026.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,572,696.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 840,544.0 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 330,885.7 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 957,716.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 4,121.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,133,267.1** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,092,478.7** мянган төгрөг буюу **81.3** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 51,013.7 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 20,652.9 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг 134,013.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 17 төсөл, арга хэмжээнд 626,263.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 411,603.8 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 62,659.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, гэрээ байгуулаагүй гэх шалтгаанаар 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 171.2 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 1,206.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий

болсон нэмэлт орлого 6,252.0 мянган төгрөг зэрэг нийт **7,629.7** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,271.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 6,358.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	7	626,263.6	3	50,929.3	4	204,714.2		
Сумын ОНХО	1	92,782.4	-	-	1	92,782.4	-	-

Эх сурвалж: www.tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Байгууллагын үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 01/84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,308,641.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **13,086.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнбүрэн сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байхад хяналт тавьж хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан,
- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,
- Хөрөнгө оруулалтаар авто машин, шаардлагагүй тоног төхөөрөмж, тавилга худалдан аваагүй,
- Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, уралдаан тэмцээн, тэмдэглэлт өдрийг зохион байгуулаагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэх

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	179	2	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	174	9	
3	Засаг даргын Тамгын газар	183	176	7	
4	Хоршоо хөгжүүлэх сан	183	176	7	
5	Орон нутгийн хөгжлийн сан	183	175	8	
Нийт дүн		913	880	33	

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 913 мэдээллээс 880 мэдээллийг хугацаанд нь, **33** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 88.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	90,050.4	4	88,550.4	80.0
Зөвлөмж	4	12,144.7	4	12,144.7	100.0
Нийт дүн	9	102,195.1	8	100,695.1	88.9

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгалгүй, давтан гаргасан тул, нягтлан бодогч Ж.Өнөрмаа нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Тайлант онд үндэсний их баяр наадам, сум байгуулагдсаны тэгш ойг зохион байгуулах зардалд ОНХС-аас 146,700.0 мянган төгрөг буюу тус сангийн нийт төсвийн **36.1** хувийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 60 дугаар зүйлийн 60.1 дэх “Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь **орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна**” гэсэн заалтууд болон зорилготой нийцэхгүй байна.

Иймд үндэсний их баяр наадам, сум байгуулагдсаны тэгш ой зэрэг баярыг тэмдэглэн өнгөрүүлэх зардлыг төсөвт ачаалал учруулахгүйгээр шийдэх нь зүйтэй юм.

3. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын **төсвийн төвлөрүүлэн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр** хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчаас малын хөлийн татварын 120,000.0 мянган төгрөгийг суурь орлогод тооцож баталсан, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг багасгаснаас шалтгаалан төсвийн зардлыг санхүүжүүлэхийн тулд сумын төсвийн орлогыг хий нэмэгдүүлэн төлөвлөж, төлөвлөгөөг **47,304.4** мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **26,608.5** мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан. Үүнд:

- ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагыг 26,608.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

Аудитаар нийт **20,051.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 3 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Бэлчир 2 дугаар багийн хорооллын гудмуудад хайрган хучилттай 3 дугаар зэргийн замын далан тавих” ажлын санхүүжилтээс уг төсөл арга хэмжээг гүйцэтгэх ажлын гэрээнд тусгагдаагүй **3,000.0** мянган төгрөгийг “Мөнх эрдэм оюу ХХК”-д шилжүүлж, байгууллагаас авах авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, “Тэгш ундрэм ХХК-тай байгуулсан СЭАЗБСЗДТГ/202309027 тоот гэрээний 1.3 дахь “Гэрээний дүн гэх /59,863,723/ ..., **зураг төсвийн зардал /0/ төгрөг...**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгож, авлага үүсгэсэн санхүүжилтийг буцаан төвлөрүүлж, авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн С.Бат-Эрдэнийн ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг ЗДТГ-ын төсвөөс барагдуулсан боловч гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй **12,182.4** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр ажлаас чөлөөгдсөн албан хаагчид олгосон цалин, НДШ-ийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **2,868.9** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

ИТХ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд 527.9 мянган төгрөг,

ЗДТГ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 935.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас авто машины аккумулятор худалдан авахад 280.0 мянган төгрөг,
- Төрийн өмчийн барилгын тогтмол зардлын /80111/ арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай /80101/ холбоотой гарах тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар үйлчилгээний зардалд 1,126.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “*Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд ЗДНХ-өөс жил бүр давтагддаг урьдчилан төлөвлөх боломжтой тохижилт, үйлчилгээний буюу нохой устгалд **2,000.0** мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “*Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам*”-ын 3.1 дэх “*Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна: 3.1.2: урьдчилан төлөвлөх боломжтой...зардал ...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь : ЗДТГ-ын нягтлан бодогч Ж.Өнөрмаад **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1. Авлагатай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын 16,906.0 мянган төгрөгийн 61.1 хувьтай тэнцэх 10,327.2 мянган төгрөг нь 2011-2013 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна. Уг авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь “*Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн ХХС-ийн зээл, хүүгийн авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **45** нэр төрлийн /ИТХ-2, ЗДТГ-43/ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	26,608.5			1	26,608.5	1	26,608.5				
Дүн	1	26,608.5			1	26,608.5	1	26,608.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	1	527.9			1	527.9						
ЗДТГ	5	17,523.4	1	3,000.0	2	14,523.4	1		1	1		
Засаг дарга	2	2,000.0			1	2,000.0	1					
ТТЗ-ийн Дүн	8	20,051.3	1	3,000.0	4	17,051.3	2		1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан	1	4,879.6			1	4,879.6		
Дүн	1	4,879.6			1	4,879.6		
Нийт дүн	2	4,879.6			2	4,879.6		